

## Шилжих хөдөлгөөн хүүхдийн амьдралд: Хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ба боловсролын хүртээмж

Монгол Улсын Их Сургууль, Хүүхдийн Ядуурлын Судалгаа Бодлогын Төв,  
Их Британы Хүүхдийг Ивээх Сан, 2005

Тус судалгаа нь хэрвээ шилжих хөдөлгөөнөөс үүдсэн нийгмиийн асуудлуудыг зохицтой шийдвэрлэхгүй бол 2015 он гэхэд Монголын бүх хүүхдийг боловсролд хамруулах зорилт хангагдахгүй байж болзошгүй гэж үзэж байна. Шилжиж явсан хийгээд ард нь үлдсэн өрхүүдийн дөрөвний нэгээс илүүгийн нь амьдралын нөхцөл хүнд байгаагаас тэдний хүүхдийн ирээдүй бүрхэг байна.

### 1. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН БА ХҮҮХЭД

Монголд болон бусад улсад хийгдсэн шилжих хөдөлгөөн ба ядуурлын талаарх ихэнх судалгааны төлөвлөлт, дүн шинжилгээнд хүүхдийн асуудлыг орхигдуулсан байдаг. МУИС/ХЯСБТ/ХИС-ийн энэ судалгаа нь хүүхдийн асуудлыг тухайлан анхаарч, хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнд хүүхдүүд, тэдний гэр бүл хэрхэн оролцсон, шилжих хөдөлгөөн амьдралд нь ямар нөлөө үзүүлснийг судлахад чиглэлээ. Судалгаа нь шилжин ирэлт ихтэй хот суурин газар болон шилжин явагч олонтой хөдөө орон нутагт байгаа хүүхэд, тэдний гэр бүлийг судалж, **шилжих хөдөлгөөн нь шилжиж явсан болон нутагтаа үлдсэн хүүхдүүдийн чанартай боловсрол эзэмших байдалд ямар нөлөө үзүүлж байгаад дүн шинжилгээ хийсэн.**

#### Судалгааны аргачлал

Судалгааны найман талбар дээр харьцуулсан судалгаа хийв:

- Дорнод, Завхан, Дундговь аймгийн гурван сум (хөдөөгийн болон сумын төв);
- Сэлэнгэ, Дорнод (шилжин ирэх болон шилжин явах хөдөлгөөн аль аль нь өндөр), Завхан (шилжин явах хөдөлгөөн өндөр) Орхон(шилжин ирэлт өндөр) гэсэн дөрвөн аймгийн төв;
- Улаанбаатар хот;<sup>1</sup> Энэхүү сонголт газар зүйн хувьд улс орныг өргөнөөр хамарсан бөгөөд судалгааны талбарыг сонгоходоо шилжин ирэх/явах хөдөлгөөнийн аль нэг нь, эсвэл аль аль нь өндөр байгаа орон нутгуудыг зориуд оруулсны зэрэгцээ эдийн засгийн үйл ажиллагаа, ажил эрхлэлтийн түвшний хувьд харилцан адилгүй орон нутгуудыг хамруулахыг зорьсон юм.


Тус судалгаа нь үндэсний төлөөллийг хангасан судалгаа гэхээсээ илүүтэйгээр харьцуулсан судалгаа юм. Үүнд:

- 3-16 насны хүүхэд бүхий шилжилт хөдөлгөөнд орсон болоод ороогүй нийт 964 өрхийг хамарсан өрхийн асуулга
- оролцоонд тулгуурласан фокус бүлгийн болон гүнзгийрүүлсэн ярилцлагын аргуудыг ашиглан чанарын судалгаанд нийт 335 хүүхэд, 209 насанд хүрэгчдийг хамруулав.

#### Ядуурал, боловсрол, хүүхэд

Монгол улсад шилжилтийн дараах хоёр дахь үеийн хүүхдүүд өсч байна. Хүүхдийн боловсрол эзэмших боломж болон ядуурлын байдал нь нягт уялдаатай юм. Орлого/хэрэглээний ядуурал, түүн дотроо хүүхдийн боловсролд хамрагдахтай холбоотой зардлыг ар гэрийнхэн нь төлж чадахгүй байх явдал нь хүүхдийг чанартай боловсрол эзэмшихэд саад болж болно. Боловсролгүй байх нь хүүхдийн (болон насанд хүрэгчдийн) ядуурлын нэг үзүүлэлт юм. Боловсролын хүртээмж муу байх нь хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээ хангалтгүй байгаа, эсвэл тухайн бүлэг хүүхэд /насанд хүрэгчдийн онцлог хэрэгцээг хангах төрийн үйлчилгээ хангалтгүй байгаатай холбоотой байж болно. Жишээ нь эрэгтэй хүүхдийн боловсролын түвшин доогуур байх нь эдийн засгийн гэхээсээ бусад учир шалтгаантай холбоотой байж болох билээ. Хүүхэд насандаа боловсрол эзэмшиж чадахгүй байх нь тэдгээр хүүхдүүдийг ядуу орчинд өсч том болох, цаашлаад залгамж үе--үр хүүхэддээ ядуурлыг өвлүүлэх магадлалыг нэмэгдүүлдэг. Тиймээс хүүхдэд зориулсан хөрөнгө оруулалт нь Монголын ирээдүйд оруулж буй нэн чухал хөрөнгө оруулалт юм.

<sup>1</sup> Аймаг бол Монголын засаг захиргааны нэг нэгж, аймаг нь сумдад хуваагддаг.



Зураг 1: Шилжин ирсэн өрхүүдийн нүүх болсон шалтгаан (УБ, Эрдэнэт, Сэлэнгэ, Хэрлэн сумын нийт 331 өрх хамрагдаж өрх бүр нүүх болсон 3 хуртэлх шалтгаанаа тодорхойлсон.)

### Нүүж буй болон нүүлгүй үлдсэн хүүхэд

- Хүүхэдтэй өрхүүд нүүж байна. Тэдний нүүдэл улам эрчимжсээр байна. Mash олон тооны хүүхэд шилжин суурьшигч болж эсвэл шилжилт хөдөлгөөн ихтэй газар нүүлгүй үлдэн өсч торниж байна.
- Шилжих хөдөлгөөн цаашдаа ч үргэлжлэх хандлагатай байна. Одоогийн байршилдаа таваас дээш жил амьдарсан хот, хөдөөгийн ихэнх айл (оршин суугаа газраасаа шалтгаалаад 60-75%) цаашид нүүх төлөвлөгөөтэй байгаа аж.
- Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 4.5% -ийн эцэг эх нь хоёул эсвэл аль нэг нь хот суурин газарт шилжин явж хүүхэд нь нутагтаа үлдсэн байна. Энэхүү үзэгдэл нь үүнээс ч олон тооны хүүхдийг хамарсан байж болох нь чанарын судалгаанаас харагдаж байлаа. Ийнхүү гэр бүлүүд шилжих хөдөлгөөнөөс үүдэн хуваагдах нь хүүхдийн сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.
- Хөдөөгийн хүүхдийг сургуульд суулгахаар хот суурин руу явуулах, мөн гэрийнхэн нь хүүхдийнхээ хойноос нүүж очих явдал түгээмэл байдаг нь фокус бүлгийн хэлэлцүүлэг болон гүнзгийрүүлсэн ярилцлагаас харагдаж байв.

### Хүүхдийн ирээдүй шилжих хөдөлгөөний шалтгаан болж байгаа нь

- Хүүхдээ сургуульд оруулах болон чанартай сайн боловсрол олгох асуудал бол хот руу шилжсэн өрхүүдийн бараг гуравны нэгийнх нь хувьд (31.2%) нүүн шилжих хамгийн чухал шалтгааны нэг байлаа. Ялангуяа ойролцоо сумдаас Хэрлэн сум (Дорнод аймгийн төв) руу, Улаанбаатар, Эрдэнэт хот руу шилжин ирэгчдийн хувьд байдал яг ийм байна.
- Дээрхтэй ойролцоо тооны өрх (34.3%) ажил хайж шилжжээ. Тэдний зарим нь, түүн дээр нь нэмэгдээд малаа алдсанаас үүдэн нүүж буй (15.3%) өрхүүд шилжих хөдөлгөөнийг эдийн засгийн хүндрэлийг даван гарах арга замаа болгон ашиглаж байна. Бусад

өрхүүдийн хувьд хот газар амьдрахын ерөнхий давуу талыг харгалзаж, шилжсэнээр хүүхдийн ирээдүй ерөнхийдөө сайжирна гэж 6.2% нь үзсэн байна.


## 2. ШИЛЖИН ИРСЭН ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫН ХҮРТЭЭМЖ

### Шилжих хөдөлгөөнд орсноор боловсролын хүртээмж сайжрав уу?

- Улаанбаатар, Эрдэнэт хот, Сэлэнгэ аймаг, Дорнод аймгийн Хэрлэн сумаас судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 91.6% нь сургуульд сурч байв. Гэхдээ түүвэрт хамрагдсан сургуулийн наасны шилжин ирсэн хүүхдүүдийг шилжилт хөдөлгөөнд ороогүй хүүхдүүдтэй харьцуулан авч үзэхэд сургуулийн гадна байгаа хүүхдийн тооны хувьд гурав дахин их байж болохоор байна. Шилжсэн хүүхдүүдийн 11.9% буюу 8 хүүхэд тутмын 1 нь сургуулийн гадна байхад, шилжээгүй суурин амьдарч байгаа хүүхдүүдийн 3.6% нь сургуулийн гадна байна.
- Шилжих хөдөлгөөнд оролцсон хүүхдийн сургуулиас завсардах нь ийм хөдөлгөөнд ороогүй хүүхдийнхээс 4 дахин их байна. Шилжсэн хүүхдийн 8.9% сургуулиа орхисон байхад суурин амьдарч буй хүүхдүүдийн 2.2% нь сургуулиас гарчээ. Шигтгээ 1-д ямар хүүхэд сургууль завсардаж байгааг үзүүлэв.
- Албан бус боловсрол хүртээмжтэй байгаа эсэхийг цаашид судлах шаардлагатай. Сургууль завсардсан хүүхдэд дахин сургуульд орох, боловсролын гэрчилгээ авахад нь туслах зорилгоор байгуулагдсан албан бус боловсрол нь судалгаа явагдсан газруудад чанарын хувьд харилцан адилгүй байгаа бөгөөд ихэнх тохиолдолд санхүүжилт нь хүрэлцээгүй байгаа болно.

Улмаар сургуульд сурч байгаа болон хүүхдэд сургуульд сурхад бэрхшээл учирсаар байна. Шилжин ирсэн болон суурин байгаа хүүхдүүдийн аль алинд ийм байгаа боловч, энэ нь шилжиж ирсэн өрхөд илүү түгээмэл тохиолдож байна.

Энд шилжих ирээд аав ээжид намайг сургуульд суулгах хэцүү байсан. Сургуульд орох гэж их хайсан. Таньдаг хүн намайг энд 11-р сургуульд оруулж өгсөн. Урьд нь 5,13-р сургуульд орох гэсэн боловч нэмж хүүхэд авахгүй гээд байсан. (Хүүхдтэй хийсэн ярилцлага, Улаанбаатар)



**Зураг 2: Сургууль завсардсан хүүхэд, судалгааны талбараар, шилжин ирэгч ба суурин хүн амыг харьцуулан үзүүлэв.**

- Боловсролын зардал (өрхийн орлоготой харьцуулахад) өндөр байна. Түүн дотроо ихэнх зардал нь сургуулийн засварын мөнгө, ангийн фонд, ном сурах бичиг гэх мэт далд зардал байдаг аж.
- Эмзэг бүлгийн болон 3 ба түүнээс дээш хүүхэд нь сургуульд сурч буй өрхөд ном, хичээлийн хэрэгслийн хэлбэрээр төрөөс жилд нэг удаа олгодог 16000 төгрөгийн (ойролцоогоор 13 амдоллар) туслалцааг үзүүлэхэд сургуульд ирж буй санхүүжилт хүрэлцдэггүй байна. Сургууль уг тусламжийг олон хүүхдэд хуваан олгоход хүрдэг. Энэ нь судалгааны бүхий л талбарт түгээмэл байв. Тиймээс хүүхдээ сургуульд явуулахдаа хамаатан садан болон бусад хүмүүсийн туслалцааг авах нь элбэг байна.
- Сургуулиуд нь айлуудаас, ялангуяа шилжиж ирсэн өрхийн амьдарч буй газраас нэлээд хол байдаг нь хүүхдүүдийн аюулгүй байдал болон тээврийн хувьд бэрхшээлтэй асуудал үүсгэдэг ажээ.

#### Шигтгээ 1: Шилжин ирсэн ямар хүүхэд сургууль завсардаж байна вэ?

Судалгааны 4 талбарт 32 өрхийн 43 шилжиж ирсэн хүүхэд сургууль завсардсан байв. Тэдний 28.6% (12)-ийг хот суурин газрын сургууль аваагүйгээс завсарджээ. 16.3% (7) нь сургууль ойр байхгүйгээс, харин 16.3% (7) нь малmallахын тулд сургуулиа орхисон байна. Түүнчлэн 11.6% (5) нь боловсролын зардлыг төлж дийлэхгүйгээс сургуульд явдаггүй байна. Үлдсэн 12 хүүхэд бусад шалтгаанаар сургуулиа орхижээ.

Сургууль завсардаж байгаа хүүхдүүдийн дүр зураг дараах байдалтай байна:

- Нийслэлд амьдарч байгаа;** Сургууль завсардсан 43 хүүхдийн 70% нь Улаанбаатарт ирсэн хүүхэд байна (нийт хүүхдийн 40% нь нийслэл рүү нүүж иржээ).
- Сумын төв эсээл хөдөөнөөс ирсэн**
- Бүртгэл хийлгэж чадахгүй байгаа өрхийн;** 2003 оны 9 дүгээр сар хүртэл шинэ газар шилжин суурьшсан өрх хот/аймгийн захираганд хураамж төлдөг байсан.

Сургууль завсардсан хүүхдүүд ихэнхдээ ядуу өрхийн хүүхдүүд байна:

- Үндсэн хэрэгцээгээ хангах гэж тэмцэж буй өрх;** Хүүхэд нь сургууль завсардсан өрхүүдийн 50% (нийт шилжин ирсэн өрхийн 31.6%) нь өдөр тутмын хэрэгцээгээ бүрэн хангаж чадахгүй байна. Сургууль завсардсан хүүхдүүдийн ихэнх нь цахилгаангүй, гэр орноо дулаацуулах түлшгүй өрхөд амьдарч байна. Хүүхэд нь сургууль завсардсан өрхийн 43.8%, нийт шилжин ирсэн өрхийн 26 хувь нь нүүснээс хойш тэдний гэр бүлийн эдийн засгийн нөхцөл байдал бага зэрэг, эсвэл нэлээд дордсон гэжээ.
- Өмнөхөөсөө бага туслалцаа авч буй өрх;** Хүүхэд нь сургууль завсардсан өрхийн 35% нь нүүснээс хойш хамаатан саднаасаа авдаг тус дэм багассан гэжээ. (Нийт өрхийн 16%-тай харьцуулахад) Түүнчлэн нийт өрхийн 14% нь л улсаас авдаг тусламж багассан гэж үзсэн байхад дээр өгүүлсэн өрхийн 32% нь ийм хариулт өгчээ.
- Олон хүүхэдтэй өрх;** Сургууль завсардсан хүүхэд нь 6 ба түүнээс олон гишүүнтэй өрхөд амьдрах нь элбэг байна.
- Малгүй болсон, эдийн засгийн цохилтод өртсөн өрх;** Хүүхэд нь сургууль завсардсан өрхийн 32% нь (нийт өрхийн 7.8%) малаа алдсаны дараа нүүжээ.

Ихэнх хүүхэд ахлах болон дунд ангидаа (5-10/11 дүгээр ангиас) бус, харин бага ангидаа (1-4 дүгээр ангиас) завсардсан байна. Завсардсан хөвгүүд, охидын тоо адил байна. Тэдний 44% (14) нь одоо өрхийнхөө орлогод хувь нэмэр оруулж байгаа ажээ.

#### Тодотгол: Бүртгэлийн хураамж (хүнд суртал) буруутгах шалтгаан мөн байсан уу?

Уг хураамж нь шилжин ирэгчид хүүхдээ сургуульд оруулахад ноцтой бэрхшээл болж байсан нь харагдаж байна. Гэвч шилжин ирэгч

гэр бүлийн өмнө тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд нь ядууралтай болон сургууль, хууль тогтоомжтой холбоотой олон хүчин зүйлэс үүдэлтэй байдаг. Уг хураамжийг үгүй болгосон нь нааштай нэг алхам мөн боловч шилжин ирэгчдэд тулгарч буй бүх бэрхшээлийг шийдэж буй хэрэг биш юм.

**Хотын багш нар хөдөөнөөс шилжин ирсэн хүүхдүүдийг хөдөө рүүгээ буцаад яв, манай ангийг битгий гутаагаад бай гэж загнадаг. (Хүүхэдтэй хийсэн ярилцлага, Эрдэнэт)**

### Боловсролын чанар хот газар илүү байна уу?

Ихэнх газарт шилжих хөдөлгөөнд оролцогч хүүхэд, тэдний гэр бүл шинээр шилжин суурьшсан газар нь боловсролын чанар өмнөх орон нутгаас нь илүү байна, ялангуяа заах арга чадвар илүү байна гэж үзсэн байна. Гэвч, энд анхаарвал зохих дараах асуудлууд байна. Үүнд:


- **Хүчин чадал, хөрөнгө нөөц.** Шилжин ирэлт өндөртэй хотын сургуулиуд хэт олон хүүхэдтэй болоод байна. Энэ асуудлыг ихэвчлэн 3 зэлжээр хичээллэх замаар шийдэхийг оролдож байна;
- Хот суурин газарт шилжин ирсэн хүүхэд хичээл хоцролтой байдаг тул сургууль дээр тэднийг **ялгаварлан гадуурхах** байдал хааягүй гардаг.

Өөр өөр сургууль, газар нутгийн хүүхдийн байдал харилцан адилгүй ялгаатай байлаа. Хөдөө сумас аймгийн төв Хэрлэн суманд шилжин ирсэн хүүхдүүд тэдний боловсролын байдал их сайжирсан гэж хэлж байна. Хөдөө орон нутаг болон бусад суурин газраас Улаанбаатар, Эрдэнэт хотод шилжиж ирсэн хүүхдүүд илүү их бэрхшээлтэй тулгарч байна. Энд сургуулийн хүчин чадлын асуудал мөн хамаарна. Сурагчдын тоо хотын сургуулиудад хэт өндөр байлаа. зэрэг Зарим газар, тухайлбал Сэлэнгэ аймагт багш, захираг, боловсролын ажилтан нь хүүхдийн амьдрал, сайн сайхан байдалд эерэгээр нөлөөлдөг болох нь харагдсан.

Хоёр шаталтай тогтолцоо үүсч байна уу? Хотын захын хороололд боловсролын чанар хотын төвийнхөөс доогур байна. Хотын төвийн өрхүүд жилийн төлбөртэй тусгай анги, сургуульд хүүхдээ сургах нь ихсэх хандлагатай байна. Төрөөс боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд хүндрэлтэй байгаа нь үнэн хэдий ч хүүхэд чанартай боловсрол эзэмших эсэх нь гэр бүлийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарч байгаа нь боловсролын хүртээмж тэгш байх тухайд сэтгэл зовоосон зүйл болж байна.

**Түүнчлэн шилжих хөдөлгөөн нь хүүхдийн сайн сайхан байдал, өрхийн амьдралын бусад асуудалд нөлөөлж, тэр нь цаашлаад хүүхэд сургуульд хэр амжилттай сурхад нь нөлөөлж байна.** Олон өрх нөхцөл байдлаа дээрдсэн гэж үзэж байгаа ч дөрвөн өрх тутмын нэг нь шилжин суурьшснаар амьдрал сайжраагүй гэж үзсэн.

**Fig 3: Household economic situation after migration, compared with before moving**



- Өрхийн орчин нь хүүхдийн гэрийн даалгавраа хийхэд чухал байдаг: Гэтэл шилжин суурьшигчид цахилгаан эрчим хүч ашигладаг байх магадлал багатай байна.
- Шилжин ирэгч дөрвөн өрх тутмын нэгийн орлого нь буурчээ. Судалгаанд хамрагдсан өрхийн 36.2% нь нүүснээс хойш эдийн засгийн байдал нь бага зэрэг эсвэл нэлээд сайжирсан гэж үзсэн байхад 37.7% нь хэвэндээ, 26% нь дордсон гэжээ. Шилжин ирсэн өрхүүд шинэ газар ажил олох гэж зүдэрч байгаа ба албан бус секторт (цаалин багатай, баталгаа муутай, илүү цагаар ажилладаг) голдуу ажилладаг байна. Шилжин ирсэн өрхийн 31.6% нь өдөр тутмын үндсэн хэрэгцээгээ ч хангаж чадахгүй, 49.4% нь зөвхөн үндсэн хэрэгцээгээ л залгуулж байна гэжээ. Суурин амьдрагч өрхүүдийн хувьд ийм бэрхшээлүүд тулгардаг ч шилжин ирсэн өрхийн хувьд нөхцөл байдал илүү хүнд байна. Уртасгасан цагаар ажиллах, эсвэл ажилгүй байх зэрэг нь хүүхэдтэйгээ хамт байх цаг хугацаанд нөлөөлж, мөн гэр бүлийн дотоод харилцаанд хүндрэл үүсгэдэг ажээ.
- Шилжин суурьшсан хүүхдүүдийн хувьд амьдрал илүү хүнд болж байна. Шилжин ирэгсэд олонгой хороолол дахь ядуу өрхийн хүүхэд ус авах, тулээ хагалах гэх мэт олон төрлийн ажилд дарагдаж, мөн ачаа зөөх, жижиг худалдаа хийж орлого олох зэрэг үүрэг хариуцлага хүлээж байна.
- Шилжин ирсэн өрхийн амьжиргааны өртөг, ялангуяа боловсролтой холбоотой зардал нь нүүж ирснээс хойш нэмэгдсэн байна.

### **3. НҮҮЛГҮЙ ҮЛДЭГЧДИЙН БОЛОВСРОЛ, АМЬДРАЛЫН БОЛОМЖ, БОЛОЛЦОО**

Хөдөө орон нутагтаа үлдсэн бол амьдрал арай дээр байх байсан уу? Шилжин явах хөдөлгөөн өндөртэй орон нутагт шилжилгүй үлдсэн хүүхдийн нөхцөл байдал ямар байна вэ?

**Шилжин явах хөдөлгөөн өндөртэй газар хүн амын тоо цөөрч, үйлчилгээ дордож байна.**

- Хөдөөд шилжин явах хөдөлгөөнөөс үүдэн сургуульд сургачдын тоо цөөрч, хүн амын өсөлт ч буурч байна.
- Хөдөөгийн сургуульд сурч буй хүүхдүүдэд дараах бэрхшээл тохиолдож байна:
  - Сургуулийн орчин, ялангуяа өвөлдөө хасах 40 хэм хүрдэг орны хувьд халаалт муутай байх;
  - Тоног төхөөрөмж, хэрэгслийн олдоц;
  - Сургалтын стандарт муудаж байна. Багш нарт зориулсан сургалт хангалтгүй, хүүхдийг сайн сургах дарамт, шахалт ихсэж байгаа тухай багш нар ярьж байна. Олон багш өөрийн мэргэжлийн хичээлээс гадна хэд хэдэн хичээлийг давхар заадаг ажээ.
- Эдгээр бэрхшээл нь эргээд хүүхэд, тэдний гэр бүлийг хот газрыг зорихд хүргэж байна.
- Сургуулиуд хаагдах аюул дор ажиллаж байна. Сургууль хаагдвал хүүхдүүд ойролцоо сумын төвийн сургуульд суух хэрэгтэй болно. Хүүхдийн тоо цөөрч, сургуулийн төсөв багасах нөхцөл байдал улам газар авах бололтой.

#### **Боловсролын орчны талаар хүүхдийн дүрслэл:**

##### **Шилжин ирэх хөдөлгөөн өндөртэй газрын сургуулийн орчин**

- Сургуулийн байшин их гоё
- Дотуур байр тохитой
- Анги нь зайд муутай
- Нэг ширээнд гурван хүүхэд суудаг
- Төрөлжсөн ангиудтай
- Биеийн тамирын заалтай
- Мэдээлэлд ойр

##### **Шилжин явах хөдөлгөөн өндөртэй газрын сургуулийн орчин**

- Их хүйтэн, өвөлдөө халаалт зогсдог
- Биеийн тамирын заалгүй
- Биеийн тамирын заал маш хүйтэн
- Ном, сургалтын материал байхгүй
- Хөдөөд компьютер байдаггүй
- Номын санд суух боломжгүй

##### **Хөдөө дэх боловсролын хүртээмж**

- Хөдөөд хоттой харьцуулахад илүү олон хүүхэд сургуулийн гадна байгаа юм.
- Хүүхэд сургууль завсардах нэг үндсэн шалтгаан нь боловсролын зардал аж. Зарим нь өрхийн

орлогод хувь нэмэр оруулах гэж сургуулиа орхиж байна. Хөдөөд мал хариулах гэж сургуулиас гарах нь хөвгүүдийн сургууль завсардах нэг үндсэн шалтгаан болсон хэвээр байна.

- Хүүхэд сургууль завсардах өөр нэг үндсэн шалтгаан нь **эрүүл мэндийн** асуудал юм. Гэр орны ядуу орчин, эрүүл мэндийн үйлчилгээ мую, эрүүл мэнд мую байгаа нь ядуурлаас үүдэлтэй байна. Энэ асуудлыг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.
- Түүнчлэн сурах сонирхолгүйгээс сургууль завсардаж байна. Энэ нь боловсролын чанар мую, магадгүй сургалтын агуулга нь хөдөөгийн амьдралд ач холбогдол багатай зарим талаар тусган харуулж байж болох юм. **Ядуу өрхөд төрөөс үзүүлж буй материаллаг туслалцаа хотод ч мөн адил хангалтгүй байна.**
- **Албан бус боловсрол туйлын хангалтгүй байна.** Эл сургалтын чанар нь газар бүрт харилцан адилгүй, хөдөөд бол зөвхөн зун хичээллэдэг бөгөөд, санхүүжилт хангалтгүй байна. Хүүхэд цуглуулах, түүнчлэн зуны амралтын үеэр хичээл заах нь багш нарт хүндрэлтэй байдаг.

##### **Өрхийн амьжиргаа**

Судалгаанд хамрагдсан орон нутаг дахь боловсролын энэ уналтын байдал нь тэдгээр орон нутгийн эдийн засгийн уналт, хүүхдийн өмнө тулгарч буй бусад олон бэрхшээлтэй асуудлын зөвхөн нэг хэсэг юм. Тухайлбал:

- Гэртээ гэрэл цахилгаангүй байх (гэрийн даалгавар хийхэд хүндрэлтэй)
- Эцэг эх нь ажилгүй байх, үүнээс үүдэн гэр бүлд үүсч буй дарамт. Шилжих хөдөлгөөнд ороогүй хөдөөгийн гэр бүлийн **44%** нь, өнгөрсөн таван жилийн хугацаанд тэдний эдийн засгийн байдал дордсон гэжээ. Судлагдсан гурван сум, алслагдсан нэг аймгийн төвийн хувьд, нийт өрхийн **37%** нь өдөр тутмын наад захын хэрэгцээгээ ч хангаж чадахгүй байна гэж үзсэн байна (энэ нь шилжин суурьшигч болон хот газар удаан хугацаагаар суурьшсан өрхтэй харьцуулахад өндөр хувь юм).
- Өрхийн амьжиргаандаа нэмэр болохын тулд хүүхдүүд гэрийн болон орлого олох ажил хийж байна.
- Хөдөөд эрүүл мэндийн үйлчилгээ доголдож байна.

##### **Шилжих хөдөлгөөн ба ядуурал**

**Хамгийн ядуу хүүхдүүд шилжин нүүж байна уу?**

Ядуурлыг үнэлэхэд хэцүү. Олон хүүхэд, тэдний гэр бүлийн амьдрал шилжин суурьших явцдаа ядуурлын түвшинд хурсэн байв. Жишээ нь, Улаанбаатарын албан ёсны тоо баримтас хараад шилжин ирж буй хүмүүсийн 80 хувь нь шилжин ирсний дараа ядуу гэж тоологдсон байна. Энэхүү судалгаанд хамрагдсан өрхүүдийн 36.2% нь шилжин суурьшнаас хойш тэдний эдийн засгийн байдал дээрдсэн гэж үзсэн. Гэвч нэн ядуу, хамгийн эмзэг хэсэг нь хөдөө, ялангуяа сумын төв дээр үлдэж байгаа дүр зураг харагдаж байна.

Тиймээс шилжих хөдөлгөөний улмаас зарим орон нутаг дахь /хөдөөд/ ядуурлын байдал улам даамжирна гэсэн үг юм. Тэдгээр орон нутагт шилжин явах хөдөлгөөн, эдийн засгийн уналт, боловсролын үйлчилгээний уналт зэрэг нь хоорондоо харилцан холбоотой ажээ. Өрхийн 44% нь эдийн засгийн байдал сүүлийн жилүүдэд дордсон гэж үзсэн байна. Нуулгүй ард үлдсэн эдгээр хүүхэд, тэдний гэр бүлийн хувьд, ялангуяа нэн ядуу хүмүүсийн хувьд ирээдүй тун бүрхэг байна.

### **Шилжин суурьшсан хүүхдийн байдал дээрдэж байна уу?**

Нэлээд олон тооны өрхийн хувьд (дөрвөн өрх тутмын нэгд) шилжин суурьшсанаар амьдрал нь бүр хэцүүддэжээ. Нүүж байгаа хүмүүсээс арай чадалтай, бололцоотой, хотод хамаатан садантай хүмүүсийн амьдрал шилжиж суурьшснаар харьцангуй сайжирч байна. Гэвч тийм бололцоогүй хүмүүсийн хувьд шилжин суурьшсаны дараа олон бэрхшээлтэй тулгарчээ.

Энэ нь цаг хугацааны асуудал байж болох юм. Судалгаанд хамрагдсан шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүмүүс нь ихэвчлэн таваас дээш жилийн өмнө мөн шилжин суурьшсан байна. Амьдрал хэцүү байгаагаа илэрхийлж буй удаан хугацаанд суурин байсан өрхийн хүмүүс ингэж үзэж буй шилжин ирэгчдээс тооны хувьд цөөн байна. Хэдийгээр хот газар амьдрал яваандаа сайжирч болох ч ялангуяа бага насын хүүхэдтэй шилжин суурьшигчид олон байгаа өнөөгийн нөхцөлд богино хугацаанд хүүхдийн сайн сайхан байдалд нөлөөлөх сөрөг үр дагавар ихтэй. Хүүхэд нас бол хүний амьдралд зөвхөн ганц удаа тохиолдоод өнгөрөх хөгжлийн үе билээ.

Эдийн засгийн уналтанд орсон хөдөө нутгаас шилжин ирэгчдийн хувьд одоо байгаа амьдрал нь шилжилгүй нутагтаа үлдсэн бол ямар байх вэ гэдэгтэй харьцуулахад дээшилсэн мэт санагдаж байгаа бөгөөд цаашид сайжрах магадлалтай. Гэхдээ зарим хүмүүсийн хувьд хот суурин газарт шилжин ирснээр ядууралд улам гүн автаж байна. Энэ тохиолдолд хүүхдийн сурах боломж багасаж байгаа тул урт хугацааны сөрөг үр дагавартай юм. Ийм нөхцөлд өсөж буй хүүхэд сайн боловсрол

эзэмшиж чадалгүй өсч, эдийн засгийн хувьд бие даах боломж туйлын багатай билээ.

*Манай аав бид хоёр их холоос мод авчирдаг. 30 км байх. Өвөл их хүйтэн болохоор мод цуглуулах их хэцүү. ...Мод хагалах ч бас хэцүү. Шуудай түлээг 500 эсвэл 600 төгрөгөөр хагалдаг, гэхдээ бид хүмүүсийн өгсөнийг л авдаг (Халхгол сум, 11 настай сургуульд сурдаггүй эрэгтэй хүүхэд)*

*Би мөнгөө ээждээ өгнө, ээж мах, сүү авдаг. Ээжийн тэтгэвэр хоол хүнс авахад л хурдэг (Халхгол сум, сургууль сурдаггүй эрэгтэй хүүхэд)*

## **4. ЭНЭ БҮХЭН ЯАГААД ИЙМ БАЙДАЛТАЙ БАЙНА ВЭ?**

### **Ачаалал нь хэтэрч буй боловсролын систем**

Судалгаанаас хэд хэдэн асуудлыг онцлон тэмдэглэж байгаа ч тэдгээрийн олонх нь цоошинэ асуудал биш юм. Гэхдээ хүн амын шилжилт хөдөлгөөний цар хүрээ, түүний хүүхдэд үзүүлж буй нөлөөг тодорхой болгосноор уг асуудлыг шийдэх боломжийг нэмэгдүүлж байгаа билээ.

- Эмзэг давхаргын хүүхдийг сургуульд хамруулах замаар тэгш байдлыг хангах арга хэмжээнд тэргүүлэх ач холбогдол өгөхгүй байна.** Эмзэг давхаргын хүүхдүүдийн сургуульд сурах боломжийг дээшлүүлэх арга хэмжээнүүд, тухайлбал 16000 төгрөгийн туслалцаа, албан бус боловсрол зэрэг нь хангалтгүй, санхүүжилт нь хүрэлцээгүй харрагдаж байна. Сургуульд сурагчдын тоог олон байлагах сонирхолтой (хүүхдийн тоогоор санхүүжүүлж буй тухай дор дурдсан хэсгийг харна уу) байгаагаас сургууль завардсан хүүхдийн тоо бүрэн, үнэн зөв гардаггүй аж. Энэ нь цаашлаад албан бус боловсролын үйлчилгээг бодитой төлөвлөхөд ч бэрхшээл учруулдаг. Хот суурин газрын сургуульд шинээр шилжин орж буй хүүхдийн хэрэгцээг харгалzan үзэх, тухайлбал хичээлээ гүйцэхэд нь туслах тусгай нэмэлт хичээл зэрэг арга хэмжээ үгүйлэгдэж байна.

- Багш нарын сургалт, нэмэлт урамшуулал.** Сурагчдын сурлагын дүнгээс хамааруулан багш нарт урамшуулал олгодог зарим практик нь хичээлээ гүйцэж авахад цаг хугацаа, дэмжлэг хэрэгтэй байдаг ядуу болон шилжиж ирсэн хүүхдэд багш нарын зүгээс ялгавартай хандахад нөлөөлж байна. Багш нарт албан бус

боловсролд хүүхэд хамруулах шаардлага тавигддаг: үүнийг багш нар ихэвчлэн нэмэлт ажил гэж үздэг бөгөөд эргээд албан бус боловсролын ангид таагүй хандахад хүргэж болзошгүй юм. Хөдөө орон нутгийн сургуулиудад багш нар очиж ажиллах сонирхлыг төрүүлэх хэрэгтэй. Халх гол сум зэрэг зарим газар шинээр сургууль төгсөгчдийг суманд ирж багшаар ажиллахыг нь дэмжсэн олон аргыг туршиж үзсэн байна.

- **Боловсролын салбарын төсөв нь улсын хэмжээнд чанартай боловсролын үйлчилгээг үзүүлэхэд хүрэлцэхгүй байна.** 2001 оны байдлаар Засгийн газрын нийт төсвийн зардлын 20%, ДНБ-ний 8.9%-ийг боловсролын салбарт зарцуулж байв<sup>2</sup>. Гэвч ийм төсвийн бодит үнэ цэнэ, түүнчлэн нөөцийн үр өгөөжтэй зарцуулалт нэн чухал юм. Хөдөөгийн зарим сургуулийн байдлаас хараад халаалт гэх мэт наад захиын тогтолцоог бий боловсролын тогтолцоог сэргээхэд хангальгүй байна.
- **Хүүхэд шилжин явахын хэрээр санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо нь хөдөөгийн сургуульд бэрхшээл учруулж байна.** Сургуульд өгч буй төсвийн нэг хэсэг нь багшийн цалин, ном, үйл ажиллагааны зардал зэрэгт зарцуулах 'хувьсах зардал' хэлбэрээр ирдэг. Сургууль хэдий чинээ олон хүүхэдтэй байна, төдий чинээ их төсөв авна. Энэ нь хүүхэд нь цөөрч, сайн багш дутагдаж, барилга байшин нь засвар үйлчилгээ шаардаж буй хөдөөгийн сургуульд илүү хүнд тусдаг байна. Түүнчлэн судалгаанаас үзэхэд хөдөөгийн зарим сургууль шилжиж буй хүүхдийн бичиг баримтыг өгдөггүйгээс хотын сургуульд элсэн ороход бэрхшээлтэй тулгардаг ажээ.
- **Боловсролын салбарт үзүүлж буй гадны тусламж асуудлыг шийдэхэд илүү чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.** Азийн хөгжлийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага гэх мэт хандивлагч болон бусад олон байгууллага боловсролын салбарт дэмжлэг үзүүлж байна. Хандивлагчид хөдөө гэхээсээ хотын (Улаанбаатар) сургуульд тулхүү анхаарч байгаа юм. Уг дэмжлэг нь салбарын хөгжил болон дэд бүтцэд хөрөнгө оруулахад голлон чиглэж байна: үндэсний түвшний бодлогыг дэмжих, засгийн газрын тогтолцоогоор дамжуулан ажиллах тал дээр хандивлагчид удаан байна.

Түүнчлэн, төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон Боловсролын тухай хуулийг тэдгээр хуулийн дагуу төсөв боловсруулах улам их хариуцлага хүлээх болсон сургууль, орон нутгийн засаг захиргааны ажилтнууд тэр бүр сайн ойлгоогүй хэвээр байна. Төсвийн мөнгийг сургуулиудад хүргэхэд аймаг ямар үүрэг гүйцэтгэж байгаа, энэ нь хэр үр дүнтэй байгааг энэхүү судалгаанд зориуд авч үзээгүй боловч цаашид судлан үзэх шаардлагатай юм.

### Ядуурлыг бууруулах бодлого

Шилжин суурьшсан болон шилжин явах хөдөлгөөн ихтэй газар шилжилгүй үлдсэн хүүхдүүдэд тулгарч буй асуудлын үндэс нь зөвхөн боловсролын салбараас үүдэлтэй биш билээ. Сүүлийн хуудсан дээрх зурагт Монгол дахь хүүхдийн боловсролын хүртээмжид нөлөөлж буй янз бүрийн бодлогын нөлөөллийг зураглан үзүүлсэн. Тэдгээрээс заримыг дурдвал:

- Шилжилтийн үеийн турш хийгдэж ирсэн эдийн засгийн шинэчлэл нь өрхийн амьжираанд ихээхэн нөлөөлсөн бөгөөд түүнээс ашиг хүртээгүй өрх олон байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги боловсрогдох хүртэлх хугацаанд ядуучуудыг дэмжих бодлого нь ядуурлыг бууруулах асуудалд төсөлд суурин арга барилаар хандаж иржээ. Ядуурлыг бууруулах, тэгш боломжийг олгоход чиглэсэн салбарын бодлогыг боловсруулахад тэргүүлэх анхаарал хандуулдагүй байв.
- Гол бодлого нь хувийн хэвшлийг дэмжсэн эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэж байсан бөгөөд одоо ч хэвээр байна. Эдийн засгийн өсөлт нь ядуурлыг тууштай бууруулахад чухал боловч зөвхөн түүгээр хязгаарлах нь хангальгүй юм. Эдийн засгийн өсөлт нь ядуу өрхийн /тухайлбал суурин газарт албан бус салбарт ажиллаж буй шилжин суурьшигчид, хөдөө орон нутагт буй ажилгүйчүүдийн/ амьжираанд эерэгээр нөлөөлөхөөр төлөвлөгдсөн байж шаардлагатай.
- Өргөн уудам нутагтай тус улс нь засаг захиргааны 331 сумдад хуваагдсан, сум тус бүр нь өөрийн дэд бүтэц, үйлчилгээний болон бусад хэрэгцээтэй, тэдгээр нь шилжилтийн үед зарим орон нутагт ихээхэн дордсон бөгөөд нөөцийн хүрэлцээ хангальгүй хэвээр байна.

### 5. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

**Хүн амын хөдөлгөөн ихтэй, өргөн уудам нутагтай улс орны хувьд үйлчилгээг хэрхэн**

<sup>2</sup> Монгол Улсын Засгийн газар, 2003, Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги, Улаанбаатар. 2005 онд төсөвт нийт зардлын 16.5%-ийг зарцуулахаар төлөвлөсөн.

## ТЭГШ ХҮРТЭЭХ ВЭ?

**Боловсролын салбарт төсөв хуваарилж буй механизмыг шат дамжлагыг эргэн харах.**

Төсвийн зарцуулалтын байдлын талаар хийгдэх судалгаа нь шилжих хөдөлгөөн энэ асуудалд хэрхэн нөлөөлж байгааг авч үзэх, төсөв хуваарилж буй өнөөгийн арга механизмыг нь хөдөө орон нутаг болон хот суурин газарт ямар үр нөлөөтэй байгааг нарийвчлан үзэх хэрэгтэй юм. Хүүхэд сургуульд шилжин суралцахтай холбогдон үүсэх хөрөнгийн урсгалыг сайтар хянах механизмыг хэрэгтэй.

**Хөдөөд боловсролын үйлчилгээ үзүүлж буй байдлыг эргэж харах хэрэгтэй байна.**

- Эдийн засгийн өөрчлөлтүүд, шилжих хөдөлгөөний улмаас үүсээд байгаа өнөөгийн нөхцөл хөдөө сумдын зарим сургууль, тэр ч байтугай сумд татан буугдах нөхцөл үүсэж болзошгүй юм.
- Дээрх тохиолдолд, мөн дээрх нөхцөл үүсэхгүй байх тохиолдлын аль алинд шилжилтийн өмнө өргөн хүрээтэй ажиллаж байсан дотуур байрны тогтолцоог хангалттай хэмжээнд санхүүжүүлж, хүүхдэд үзүүлэх халамж үйлчилгээг нэмэгдүүлснээр хөдөөгийн өрхүүд хүүхдээ сум, аймгийн сургуульд явуулах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Хөдөө орон нутагт сайн багшийг татах эдийн засгийн болон өөр бусад хөшүүргийг хайх хэрэгтэй.
- Өргөн уудам нутагтай орны хувьд хөдөөгийн хүүхдэд хүрч боловсрол олгох радио, шуудан гэх мэт зайны сургалтын хувилбаруудыг бий болгох шаардлагатай.

**Шилжин суурьшилт ихтэй газрын боловсролын байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх.** Энэ асуудлыг бодлогын олон баримт бичгүүдэд дурдсан байдаг ч бодит арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хотын зарим сургуулиуд гурван ээлжээр хичээллэж байгаа нь урт хугацааны гэхээсээ түр зуурын шийдэл байх ёстой.

**Нэн ядуу, хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн хөтөлбөр / үйл ажиллагаа:**

- Ерөнхийдөө, боловсролын системийн гол анхаарал нь боловсролыг бүх нийтэд хүртээмжтэй байлгах үйлчилгээг төрөөс үзүүлэх, шилжин явах болон ирэх хөдөлгөөн ихтэй газарт үйлчилгээг сайжруулахад чиглэх ёстой.
- Албан бус боловсролд хөрөнгө нөөц ахиу хуваарилах шаардлагатай бөгөөд багш нарт ирж бий нэмэлт дарамт гэж тооцогдох ёсгүй.
- Сургалтын хэрэгслийн туслалцаа үзүүлж байгаа нь хэр оновчтойг эргэн нягталж, хэрэгцээтэй байгаа бүх хүүхдийг хамрах, хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

- Хотод шилжиж ирсэн хүүхдэд хичээлээ гүйцэхэд нь зориулж нэмэлт дэмжлэг үзүүлэх шаардлагатай. Багш нар шилжиж ирсэн хүүхдийг гадуурхах биш дэмждэг байх хөшүүргийг бий болгох хэрэгтэй.

Дунд хугацаанд, хандивлагчдын тусламжийн илүү их хэсэг нь улсын хэмжээгээр, үйлчилгээний тэгш байдлыг хангахад чиглэгдэх ёстай. Монголд ажиллаж буй хандивлагчид үзүүлж буй тусламж дэмжлэгээ үүнтэй илүү уялдуулах, үндэсний бодлогыг дэмжих, засгийн газрын бүтцээр дамжуулан ажиллах нь чухал байгаа болно.

## Аливаа бодлого боловсруулахад ядуу хүүхэд, тэдний гэр бүлд эерэг нөлөөтэй байхаар боловсруулах

**Эдийн засгийн болон нийгмийн бодлогыг тэнцвэртэйгээр хэрэгжүүлэх бүсийн хөгжил**  
Саяхан боловсруулсан бүсчилсэн хөгжлийн бодлого нь шилжих хөдөлгөөнийг сааруулахын тулд улс орны хэмжээнд хэрэгжих нийгмийн болон эдийн засгийн бодлогод илүү анхаарал хандуулах шаардлагатай. Шилжин нүүж буй өрхийн бараг гуравны нэг нь хүүхдийнхээ боловсрол, сургуулийг сайжруулах зорилготой нүүж байна. Сум, аймгийн төвд улсын сайн сургуультай байх нь тухайн нутагт хүүхэд, тэдний гэр бүлийг татах нь дамжиггүй.


**Шинэчлэл нь ядуу хүүхэд, тэдний гэр бүлд ямар нөлөөтэй болохыг харгалзан үзэх.**  
Орон нутгуудын болон хүмүүсийн хооронд баян хоосны ялгаатай, тэгш бус байдлыг багасгах, цаашид ийм байдлыг арилгахын тулд аливаа бодлогын сонголт хийхдээ (шийдвэр гаргахдаа) тухайн бодлого нь ядуу болон эмзэг давхаргын хүмүүст хэрхэн тусахыг үнэлж үздэг байх шаардлагатай. Дэлхийн банк, Олон улсын валютын сангаас дэмжин хэрэгжүүлж буй судалгаа шинжилгээ болон эдийн засаг, нийгмийн бодлогын талаар үндэсний түвшинд хийгдэж буй дүн шинжилгээ, хэлэлцүүлэг нь эмзэг бүлэгт тусах/тусч буй үр нөлөөг авч үзэж байх хэрэгтэй.

**Ирээдүйд чиглэсэн төлөвлөгөө, хүүхдийн сайн сайханд зэрэгээр нөлөөлөх эдийн засаг, нийгмийн бодлого.** Хүүхдийн нөхцөл байдлыг эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги болон бүсийн хөгжил, худалдааны бодлого зэрэг бодлогын үндсэн чиглэлүүдэд уялдуулан авч үзэх шаардлагатай. Хүүхэд бол тухайлсан байгууллагуудаас тусгай төсөл/ажиллагаа шаарддаг нийгмийн 'тусгай бүлэг' төдий биш. Хүүхдүүд Монгол улсын хүн амын бараг 50%-ийг эзэлдэг, ихэнх бодлого тэдэнд ямар нэг хэлбэрээр нөлөөлж байдаг ажгуу.

Энэ бол МУИС/ХЯСБТ/Их Британы Хүүхдийг Ивээх Сангаас хамтран хийсэн “**Шилжих хөдөлгөөн хүүхдийн амьдралд: Хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ба боловсролын хүртээмж**” судалгааны тайлангийн товч тойм юм.

Тайлангийн бүрэн эхийг [www.childhoodpoverty.org](http://www.childhoodpoverty.org) эсвэл [www.savethechildren.mn](http://www.savethechildren.mn) хаягнаас харна уу. МУИС/ХЯСБТ/ХИС энэхүү тоймд дурдсан мэдээлэлд засвар оруулах эрхтэй. Судалгааны бүрэн тайлан болон энэ хураангуй тойм нь англи, монгол хэл дээр хэвлэгдсэн болно.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Монгол дахь Их Британий, Хүүхдийг Ивээх Сангийн Хөтөлбөрийн захирал Чулууны Тунгалаг, Хүүхдийн Ивээх Сангийн, Хүүхдийн ядуурлын судалгаа, бодлогын төвийн ажилтан Женни Маршал болон МУИС-ийн Социологийн тэнхимийн багш Цэвэгдоржийн Болд, Гэлэнхүүгийн Түмэннаст, Монхооройн Батбаатар, Чүлтэмсүрэнгийн Тамир, Дугарсүрэнгийн Оюунцэцэг нарт хандана уу.



Дун шинжилгээний хүрээ: Монгол улсад хүүхэд чанартай боловсрол эзэмших боломж/хүртээмжид нэлөөлж буй чухал хүчин зүйлс (МУИС/ХЯБСТ/ХИС-гийн судалгааны дүнгээс, 2002-2004)